СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Ч.ӨНӨРСАЙХАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АГААР СЭЛГЭЛТИЙН СИСТЕМИЙГ САЙЖРУУЛАХ ЗАСВАРЫН АЖИЛ (УЛААНБААТАР ХОТ)-ЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2025.08.11 Дугаар № 2025/07 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/20 дугаар захирамж.
2.	Барилга байгууламжийн байршил	- Сонгинохайрхан дүүргийн 13-р хороо Залуус гудамж Эрүүл мэндийн төв
3.	Зориулалт хүчин чадал	Эрүүл мэндийн байгууллагуудын агаар сэлгэлтийн системийг сайжруулах төслийн хүрээнд: Эрүүл мэндийн төвийн Өргөтгөлийн барилгын агааржуулалтын системийг засварлаж, ашиглалтад оруулах, Барилгын нийт талбай – 5007 м2 8 давхар барилга Өргөтгөлийн барилгын 2 давхарт байрлах Нийт талбай 304,2 м2 оношзүйн тасгийн агааржуулалтын системд нэмэлт, өөрчлөлт хийж бие даасан агааржуулалтын ситемийг бий болгох.
4.	Төслийн гүйцэтгэх хугацаа	- Захиалагч, гүйцэтгэх талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
5.	Төслийн иж бүрдэл	Баримт бичгийн иж бүрдэл: • Нүүр хуудас /батлагдах/ • Байршлын схем • Тайлбар бичиг, зургийн жагсаалт • Хэмжилтийн байгуулалт • Засварын ажлын байгуулалт, ажлын зураг • Заслын ажлын тодорхойлолт • Засварын төсөв Зураг төсөлд тавигдах шаардлага: Зураг төслийн баримт бичиг 1 эх хувь, 2 хуулбар хувь боловсруулна. Үүнээс график зураглал CD -ний хамт 2хувийг Захиалагчид үндсэн хувийг архивд өгнө өө. Ажлын зурагт одоогийн байдал болон төлөвлөлтийг Нэг дэвсгэр зураг дээр нэгтгэн хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж норм Стандартын дагуу төлөвлөж ашиглагч байгууллагатай зөвшилцсөн байх шаардлагатай.
6.	Зураг төсөл боловсруулах үе шат	- Хэмжилтийн болон өөрчлөлтийн ажлын зураг, төсөв боловсруулж, батлуулах;
7.	Зураг төслийн байгууллага	- Барилга хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт засвар, үйлчилгээ, материалын үйлдвэрлэл, угсралт засвар, үйлчилгээ, материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам"-ын

		Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд:
8.	Захиалагч байгууллага	- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар - Нийслэлийн Эрүүл мэндийн газар
9.	Засвар хийгдэх ажлууд	❖ Эрүүл мэндийн төвийн Өргөтгөлийн барилгын агааржуулалтын системийг засварлаж, ашиглалтад оруулах, Барилгын нийт талбай – 5007 м2 8 давхар барилга. Тус агааржуулалтын систем нь өргөтгөлийн барилга ашиглалтад орох үеэс эхлэн ажилаагүй ➢ Төхөөрөмжүүдийн угсралтыг шалгах, ➢ хөлдөж хагарсан шугам болон хөргөлт, ➢ халаалтын сисмемийг солих, ➢ агааржуулалтын хоолойны битүүмжийг шалгаж цэвэрлэх, ➢ шаардлагатай газруудыг дулаална ➢ автоматжуулалтын системийн ажиллагааг шалгана, ➢ шингэнээ хийх ➢ туршилт тохируулга хийх, ➢ туршилт тохируулгыг жигдрүүлнэ хугацаа- 1 сар хүртэлх Нэмэлтээр хийх санал: 1. Одоо байгаа сисмемийг ажлуулахын тулд агааржуулалтын оролт дээр цахилгаан агаар халаагчийг нэмэлтээр тавих. Хөргөлтийн ажил: 1 шугам сүлжээг шалгах 2. Хөргөлтийн гадна төхөөрөмж шалгах 3. Автомат удирдлагын системийг шалгах, шингэнээ хийх 4. Туршилт тохируулга Нэмэлтээр хийх санал: 1. Хөлддөггүй шингэн хийх 2. Гадна төхөөрөмж буюу / чиллер/ -ийг дулаалах буюу техникийн өрөө хийх. ❖ Өргөтгөлийн барилгын 2 давхарт байрлах Нийт талбай 304,2 м2 оношзүйн тасгийн агааржуулалтын системд нэмэлт, өөрчлөлт хийж бие даасан агааржуулалтын ситемийг бий болгох. Үүнд: 1. Иж бүрэн ажлын зураг, төсөв хийж гүйцэтгэх 2. Иж бүрэн хийж угсрах 3. Магадлалаар оруулах **Нийтлэг шаардлагатай зүйлс:** - Тухайн эмнэлгийн барилга болон өрөөний зориулалтаас хамаарч одоо мөрдөгдөж буй БНбД, стандартын шаардлагатай нийцүүлж агаар сэлгэлтийн систем шинээр болон шинэчилж төлөвлөх; - Агаар сэлгэлтийн систем төлөвлөхдөө агаар сэлгэлтийн тооцооны үндсэн дээр одоо байгаа системийг шинээр болон шинэчлэн засварлана. - Агаар сэлгэлтийн системийг шинээр хийх, шинэчлэн засвар хийхэд дагалдан гарах шаардлагатай засварын ажлуудыг хийх.
10.	Онцгой нөхцөл	<u>Засварын ажилд тавигдах шаардлага:</u> - Засварт ашиглах материалыг сонгохдоо орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлсэн шинэ, чанартай тохирлын гэрчилгээтэй материал байх.

		- Засварын ажил хийхэд дагалдан гарах нөхөн сэргээх зардал болон технологийн шаардлагатай ажлын тоо хэмжээг төсөвт тусган хийж гүйцэтгэх. - Даацын бүтээцэд өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулж, ажлын зураг зурах. - Төсвийг зохиохдоо заавал ажлын талбарт очиж, хэмжилт хийн фото зургаар баталгаажуулах.
11.	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Хууль тогтоомж:</u> - Барилгын тухай хууль - Эрүүл мэндийн тухай хууль <u>Норм, нормативууд:</u> - Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх /БНбД 31-22-21/ - Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер /БНбД 41-01-11/ - Олон нийтийн барилгын норм дүрэм /БНбД 31.03.03/ - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНбД 21.02.02/ - Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд - Тоног төхөөрөмж дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт /БНбД 41-03-99/ - Заслын ажил /БНбД 31-10-05/ - Дуу чимээ тусгаарлалт /БНбД 23-05-10/ - Барилга засварын ажлын төсвийн суурь нормууд - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм. - Цахилгаан техникийн ажил /БНбД 3.05.06-90/ - Автотмажуулалтын систем /БНбД 3.05.07-90/ - Дуу шуугиан. Аюулгүйн ерөнхий шаардлагууд /ГОСТ12.1.003-83 ССБТ/ - Бусад холбогдох норм, дүрэм. <u>Стандартууд:</u> - Өрөөний бичил уур амьсгалын үзүүлэлт.MNS 5825:2007 - “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” MNS 4990:2000 - “Ажлын байрны бичиг цаг уурын эрүүл ахуйн хэмжээ” MNS 12.013-91 - “Ажлын байрны хүчдэлийн түвшин” MNS 12.097-91, MNS 12.098-91, MNS 12.101-091 - Бусад холбогдох стандартууд.
12.	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ХЯНАСАН:

ЭТҮХО ДАРГА С.ЛХАСҮРЭН

ЭМНЭЛГИЙН БАЙГУУЛАМЖ ҮЙЛДВЭРЛЭЛ ХЭЛТЭС

БОЛОВСРУУЛСАН:

АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА С.БАЯРМАГНАЙ

9092101 СБТ21032 УЛААНБААТАР ХОТ